



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 247


Хэрлэн сум

Цалингийн шатлал ахиулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингээрээ хангалттай сайн үнэлэгдсэн зарим албан хаагчдын цалингийн шатлалыг ахиулан олгосугай.
2. Шатлал ахиулах албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн (С.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР